



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ХАРИЛЦАА ХОЛБОО,  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 1,  
Утас: 33-07-90, 33-07-81, Факс: (976-11) 33-07-80  
E-mail: info@cita.gov.mn, http://www.cita.gov.mn

2019.07.09 № 1/659  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**


Тус газраас зарласан “Сансрын холбооны Кэй юү зурвасын технологи ашиглан телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээ эрхлэгч”-ийг сонгон шалгаруулах ХХМТГ/201911001 тоот хязгаарлагдмал тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгын хариуг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

| № | Тодруулгын асуулт   | Тодруулгын хариулт   |
|---|---|--|
| 1 | 2   | 3  |
| 1 | Тендерийн баталгааны хугацаа нь хуанлийн хоногоор хэдэн сарын хэдний өдрийг хүртэл хүчинтэй байхаар тооцох вэ? Огноог нь тодорхой зааж өгнө үү?   | Тендерийн баталгааны хугацаа нь 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаагаар хүчинтэй байвал зохино.  |
| 2 | Энэхүү багц тус бүрийн 3 хувийн зардлыг 10 жилийн хугацаатай банкинд байршуулж хадгалах уу, эсхүл тухай бүр холбогдох зардлыг нь санхүүжүүлэх үү? | Тухайн багц тус бүрийн 3 хувийн зардлыг тухайн жилийн санхүүжилтээс хамааруулан тухайн жил тус бүрээр санхүүжүүлнэ.  |
| 3 | Тендерийн хүчинтэй байх зөв хугацаа аль нь болохыг тодорхой болгож өгнө үү.   | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24.5-д “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.” гэж заасныг баримтална.  |
| 4 | Газар зүйн 4 бүсчлэл /Улаанбаатар хотоос бусад/-д бүс тус бүрд ямар ямар аймаг багтаж байгаа талаар тодруулгыг хийж өгнө үү?                      | Багц тус бүрийн бүсчлэлд хамаарах аймгуудыг дараах байдлаар хуваасан болно.<br>- Баруун бүс (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд);<br>- Зүүн бүс (Дорнод, Сүхбаатар, Хэнтий);<br>- Төвийн бүс (Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв);<br>- Хангайн бүс (Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл) |

0002565

| 1 | 2  | 3    |
|---|--|------|
| 5 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлт /2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж буй/-ийн заалт үйлчлэх үү? | Тийм |

ДАРГА



Б.ЧИНБАТ